

Улсын бүртгэлийн  
Дугаар .....  
Аравтын бүрэн  
ангилалын код

Нууцын зэрэглэл: Б

Төсөл хэрэгжүүлэх гэрээний  
дугаар: ШуСс\_2018/02

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ  
ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ  
МАЛ ЭМНЭЛГИЙН ХҮРЭЭЛЭН

АДУУНЫ ЯМ, МАЛЫН БРУЦЕЛЛЭЗ ҮҮСГЭГЧИЙН  
ФЕНОТИП, ГЕНОТИПИЙН СУДАЛГАА

*Суурь судалгааны төслийн эцсийн тайлан*

(2018. 10 сар -2021. 12 сар, хэрэгжүүлсэн хугацаа 38 сар)

**Төслийн удирдагч:** В. Батбаатар Доктор (PhD), ХААИСургуулийн харьяа Мал эмнэлгийн хүрээлэнгийн Халдварт өвчин, дархлаа судлалын лабораторийн эрхлэгч, Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

**Санхүүжүүлэгч байгууллага:** Шинжлэх ухаан технологийн сан

**Захиалагч байгууллага:** Боловсрол, Шинжлэх Ухаан, Спортын Яам

**Тайлан өмчлөгч:** Мал эмнэлгийн хүрээлэн, ШХ: Зайсан-17024, Цахим хаяг: [www.ivm.mn](http://www.ivm.mn)

**Төслийг гүйцэтгэгчийн хаяг, утас, цахим шуудан:** ХААИС-ийн харьяа Мал эмнэлгийн хүрээлэнгийн Халдварт өвчин, дархлаа судлалын лаборатори, *Хаяг:* УБ хот, ХУД, 11-р хороо, Зайсан, Мал эмнэлгийн хүрээлэнгийн байр, 213 тоот өрөө. *Гар утас:* 99122813, *Цахим хаяг:* [vanaabaatar.b@gmail.com](mailto:vanaabaatar.b@gmail.com)

Улаанбаатар хот

2022 он

МОНГОЛ УЛС  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ  
ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ  
МАЛ ЭМНЭЛГИЙН ХҮРЭЭЛЭН

АДУУНЫ ЯМ, МАЛЫН БРУЦЕЛЛЭЗ ҮҮСГЭГЧИЙН  
ФЕНОТИП, ГЕНОТИПИЙН СУДАЛГАА

*Суурь судалгааны төслийн эцсийн тайлан*  
(2018. 10 сар - 2021. 12 сар, хэрэгжүүлсэн хугацаа 38 сар)

Гүйцэтгэгч: ЭШТА, Доктор (Ph.D), Малын их эмч	В. Батбаатар
ЭШДА, ХААИС-ийн докторант, Малын их эмч	О. Хурцбаатар
ЭШДА, ХААИС-ийн докторант, Малын их эмч	Г. Өлзийсайхан
ЭШДА, Докторант, Генетикч	Б. Гэрэлсүрэн
ЭШДА, МУИС-ийн магистрант, Биотехнологич	А. Биндэрьяа
Удирдагч: ЭШТА, Доктор (Ph.D)	В. Батбаатар

Улаанбаатар  
2022 он

## НЭР ТОМЪЁО, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДМАЭМБ	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага
ДНХ	Дезоксирибонуклейн хүчил
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МЭХ	Мал эмнэлгийн хүрээлэн
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ПГУ	Полимеразийн гинжин урвал
РБУ	Розбенгалын урвал
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХӨДСЛ	Халдварт өвчин, дархлаа судлалын лаборатори
ХАА	Хөдөө аж ахуйн
ХХУ	Хавсрага холбох урвал
СО <sub>2</sub>	Нүүрс хүчлийн хий
ФХЭБУ	Фермент холбоот эсрэг биемийн урвал
ЭЗ	Эрдмийн зөвлөл
AMOS	abortus, melitensis, ovis, sius
bp	base pair (хос нуклеотид)
Bp	Brucella protein
BCSP	Brucella cover specific protein
MSP	Majer surface protein
MSA	Majer surface antigen
CITA	new selective medium
dNTP	Deoxynucleotide triphosphate
OIE	Office International de Epizooties
Omp	Outer memberan prootein
ТАЕ буффер	Трис ацетат-эдта буффер
ТЕ буффер	Трис-Эдта буффер
WHO	Word health organization

## АГУУЛГА

	Нэр томъёо, товчилсон үгийн тайлбар	4
1	РЕФЕРАТ	5
2	ОРШИЛ, ҮНДЭСЛЭЛ	7
3	СУДЛАГДСАН БАЙДАЛ	8
4	СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	10
5	СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ	10
5.1	ҮҮСГЭГЧ ГАРГАН АВАХ, ТҮҮНИЙ ФЕНОТИП СУДАЛГАА	10
5.1.1	Бруцеллёзын үүсгэгч гарган авах, шилэн сонгох	10
5.1.2	Адууны ямын үүсгэгч гарган авах, шилэн сонгох	10
5.1.3	Шилэн сонгосон өсгөврийн фенотип судалгаа	11
5.2	ГЕНОТИП СУДАЛГАА	12
5.2.1	Геномын дезоксирибонуклейн хүчил (ДНХ) ялгах	12
5.2.2	Полимеразын гинжин урвал (ПГУ)-аар баталгаажуулах	12
5.2.3	Нуклеотидийн дарааллыг боловсруулах, генбанканд бүртгүүлэх	14
5.2.4	Удам зүйн мод байгуулах	14
6	СУДАЛГААНЫ ҮР ДҮН	15
6.1	Бруцеллёз үүсгэгчийн нян судлалын шинжилгээний дүн	15
6.2	Адууны ям үүсгэгчийн нян судлалын шинжилгээний үр дүн	16
6.3	Молекул биологийн шинжилгээний дүн	17
6.3.1	Бруцеллёз үүсгэгчийг ПГУ – аар баталгаажуулсан дүн	17
6.3.2	Адууны ямын үүсгэгчийг ПГУ-аар баталгаажуулсан дүн	19
6.4	Нуклеотидийн дарааллыг тодорхойлж, генбанканд бүртгүүлсэн дүн	20
6.5	Удам зүйн мод байгуулсан дүн	24
7	ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	27
8	ДҮГНЭЛТ	30
9	АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ	31
10	ХАВСРАЛТ	32

## 1. РЕФЕРАТ

### (ТАЙЛАНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА)

“Адууны ям, малын бруцеллэз үүсгэгчийн фенотип, генотипийн судалгаа” нэртэй суурь судалгааны ажлын арга зүйг Мал эмнэлгийн хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, батлуулсан арга зүйн хүрээнд 2018 оны 10-р сараас 2021 оны 12 сарыг дуустал нийт 38 сарын хугацаанд хийж гүйцэтгэв.

Энэхүү суурь судалгааны төслийг гүйцэтгэснээр дараах үр дүнд хүрсэн байна.

1. Малын бруцеллэз үүсгэгч 12 омог (*B. melitensis*-ийн 6, *B. abortus*-ийн 6)-ийн OMP28 генийн болон Адууны ямын үүсгэгч 1 омгийн шилбүүрийн ген (FLIP ген)-ийн нуклеотидийн дарааллыг “NCBI”-ийн ген банканд бүртгүүлэв.
2. Адууны ям, малын бруцеллэз үүсгэгч, нутгийн омог /омгийн паспорт, омгийн патент/-ийг бий болгов.

**Түлхүүр үг:** Адууны ям, малын бруцеллэз, *Brucella abortus*, *Brucella melitensis*, *Burkholderia mallei*

### ҮР ДҮНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Бруцеллэзын үүсгэгч лавлагаа 2 омог болох *B. melitensis* 16М, *B. abortus* 544 - тэй харьцуулан хониноос гарган авсан *B. melitensis* Sh-4, *B. melitensis* Sh-8, *B. melitensis* Sh-37, *B. melitensis* Sh-39, ямаанаас гарган авсан *B. melitensis* Go-9, *B. melitensis* Go-10, үхрээс гарган авсан *B. abortus* B-2, сарлагаас гарган авсан *B. abortus* Y-8, *B. abortus* Y-9, *B. abortus* Y-11 болон тэмээнээс гарган авсан *B. abortus* Cam-1, *B. abortus* Cam-2 зэрэг бруцеллэзын үүсгэгч өсгөврүүдийн фенотип үзүүлэлтийн судалгааг хийв.
2. Нутгийн малаас гарган авсан, бруцеллэзын үүсгэгч тухайлбал хониноос гарган авсан *B. melitensis* Sh-4 (GenBank accession number: **MN080914.1**), *B. melitensis* Sh-8 (GenBank accession number: **MN080914.1**), *B. melitensis* Sh-37 (GenBank accession number: **MN080914.1**), *B. melitensis* Sh-39 (GenBank accession number: **MN080914.1**), ямаанаас гарган авсан *B. melitensis* Go-9 (GenBank accession number: **MN080914.1**), *B. melitensis* Go-10 (GenBank accession number: **MN080914.1**), үхрээс гарган авсан *B. abortus* B-2 (GenBank accession number: **MN080914.1**), сарлагаас гарган авсан *B. abortus* Y-8 (GenBank accession number: **MN080914.1**), *B. abortus* Y-9 (GenBank accession number: **MN080914.1**), *B. abortus* Y-11 (GenBank accession number: **MN080914.1**) болон тэмээнээс гарган авсан *B. abortus* Cam-1 (GenBank accession number: **MN080914.1**), *B. abortus* Cam-2 (GenBank accession number: **MN080914.1**) зэрэг омгуудын гадар мембраны 28 уургийн ген (omp28)-ийн дарааллыг NCBI ГЕН банкинд тус тус бүртгүүлэв.

3. Нутгийн адуунаас гарган авсан, адууны ямын үүсгэгч болох “*Burkholderia mallei* MNGBm20180501”, “*Burkholderia mallei* MNGBm20200702”, “*Burkholderia mallei* MNGBm20200703” өсгөврүүдийн фенотип үзүүлэлтийн судалгааг хийв.
4. Нутгийн адуунаас гарган авсан, адууны ямын үүсгэгч болох “*Burkholderia mallei* MNGBm20180501” (GenBank accession number: **MZ380392.1**)-ийн шилбүүрийн ген (FLIP gen)-ийн дарааллыг NCBI ГЕН банкинд бүртгүүлэв.
5. Нутгийн адуунаас гарган авсан, адууны ямын үүсгэгчийг “Нутгийн омог *Burkholderia mallei* MNGBm20180501” **нэртэйгээр шинэ бүтээлийн патентийг авав.** (Улсын бүртгэлийн дугаар: 10-0005176).
6. Нутгийн сарлагаас гарган авсан, бруцеллэзын үүсгэгчийг “***Brucella abortus* Y-9 омог**” **нэртэйгээр шинэ бүтээлийн патентаар бүртгүүлэх өргөдлийг Монгол улсын оюуны өмчийн газарт хүргүүлээд байна.** (Мэдүүлгийн дугаар: 21-10-000????) /хүсэлт гарган хүргүүлсэн албан бичгийн хуулбарыг ХАВСПАЛТ 17-оос харна уу/.
7. ХААИС-ийн харьяа Мал эмнэлгийн хүрээлэн болон Мал эмнэлгийн сургуулиас эрхлэн гаргадаг “Монголын Мал Эмнэлгийн Шинжлэх Ухаан, Технологийн Сэтгүүл” (ISSN 2709-5126) нэрт сэтгүүлийн 2021 оны Цуврал 5-ийн Дугаар 1-т “Адууны ям өвчний үлэмж болон бичил бүтцийг судалсан дүн” нэртэй судалгааны өгүүллийг нийтлүүлсэн, хуудас 82.

## 2. ОРШИЛ, ҮНДЭСЛЭЛ

Нүүдлийн соёл иргэншилтэй манай орны хувьд мал аж ахуй бол амьжиргааны гол хэсэг билээ. Малын халдварт өвчнүүд нь мал аж ахуйн хөгжил цаашлаад хүний эрүүл мэнд, улс орны эдийн засагт ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг. Малын халдварт өвчнүүд тэр дундаа бруцеллёз нь дэлхийн олон оронд тархсан ужиг халдварт өвчин бөгөөд сүүлийн жилүүдэд уг өвчний тархалт манай оронд нилээдгүй нэмэгдэж байна. Жил бүр 500 мянган тохиолдол шинээр гарч байна гэсэн тооцоо байна.

Малаас хүнд дамждаг зооноз өвчин болох бруцеллёзоор халдварласан малд хээл хаях, амьдрах чадваргүй төл гаргах, зулбах, үе мөч нь хавдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Бруцеллёз нь хүний мэдрэл, үе мөч болоод дотор эрхтэнд нөлөөлдөг бөгөөд өвчний шинж тэмдэг архаг хэлбэрээр илэрдэг. Энэ өвчин нь *brucella* (бруцелла) төрлийн грам сөрөг бактериар үүсгэгддэг. Халдвар авсан малтай шууд (халдвартай малын арьс шир, үс ноостой ажиллах, нядлах гэх мэт) болон шууд бус (халдвартай амьтны гаралтай бүтээгдэхүүнийг дутуу боловсруулж хэрэглэх) замаар хавьтал үүсгэсэн тохиолдолд хүнд халдварладаг. Малыг арьс шир, үс ноос тэдгээрийн бүтээгдэхүүн болох сүү цагаан идээтэй ойр ажилладаг хүмүүс халдвар авах эрсдэл өндөр байдаг. Бруцеллёзоор өвчилсөн хүний хөдөлмөрийн чадавх буурч улмаар хувь хүн болоод улс орны эдийн засагт багагүй хохирол үзүүлдэг.

Ям өвчнөөр битүү туурайтан амьтад (адуу, илжиг, луус, хулан, тахь), муурны төрлийн махчин амьтад (арслан, бар, муур, чоно, үнэг), хүн өвчлөх ба уушиг, хамрын салст бүрхүүл, арьсны зарим хэсэгт идээт яр, булдруу үүсэх шинжээр илэрдэг мал, амьтнаас хүнд халдварладаг ужиг халдварт өвчин юм. Ямаар өвчилсөн хүн, адуу, малыг эмчлэх арга одоогоор бүрэн боловсрогдоогүй байгаа ба халдвартай адууг сүргээс тусгаарлан устгах заалттай байдаг.

### 3. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Бруцеллөз нь “undulant fever”, “Mediterranean fever” “Malta fever” гэж нэрлэгддэг амьтнаас хүнд халдварладаг зооантропоноз өвчин юм. Халдвартай амьтан, халдвартай бүтээгдэхүүнээр шууд болон шууд бус замаар халдвар дамждаг. Нас хүйс хамаарахгүй хүн болоод 5 хошуу мал, гахай, цаа буга, аргаль, янгир, нохой бусад ан амьтад халдварт өртдөг. Европын газар дундын тэнгис, хойд өмнөд Африк, хойд, өмнө, дундад Ази, өмнөд болон төв Америк зэрэг дэлхийн өнцөг булан бүрт тархсан. Бруцеллөз өвчин үүсгэгч микроорганизмуудыг Английн эмч Д. Брюс 1886 онд илрүүлж, судлан тусгай хэсэг болгон *Brucella* – бруцелла гэж нэрлэжээ. Бруцеллөз үүсгэгчид нь харьцангуй олон төрлийн хөхтөн амьтныг өвчлүүлдэг, эсийн доторх бактер. Эдгээр нь бактериологи, серологи, биохимийн шинжээрээ дотроо 6 зүйлд хуваагдана.

*Brucella* – ийн төрөлд доорх зүйлүүд багтана. Үүнд :

- *Brucella melitensis* (*B. melitensis*) – Хонь, ямааны бруцеллөз үүсгэгч
- *Brucella abortus* (*B. abortus*) - Үхрийн бруцеллөз үүсгэгч
- *Brucella suis* (*B. suis*) – Гахайн бруцеллөз үүсгэгч
- *Brucella ovis* (*B. ovis*) – Хуцын халдварт эпидем үүсгэгч
- *Brucella canis* (*B. canis*) – Нохой
- *Brucella neotomae* (*B. neotomae*) – Харх зэрэг мэрэгчид

Бруцелла нь спор, капсулгүй, грам сөрөг жижиг [ (0.6-1.5) x (0.5-0.7) мкм хэмжээтэй, хөдөлгөөнгүй савханцар хэлбэртэй бактер. Бруцелла нь аэроб ба анаэроб нөхцөл, нүүрсхүчлийн хийтэй орчинд мах пептоны элэгтэй агар, мах пептоны элэгтэй шөл зэрэг тэжээлт орчинд сайн өсгөвөрлөгдөнө. Мах пептоны элэгтэй агарт усан дусал мэт дугуй клон 7-10 хоногийн дараа бий болно. Харин шар сүү агуулсан тэжээлт орчинд өсгөвөрлөхөд микрокапсул үүсгэж болно. Бруцеллан клоний диаметр нь 2-7 мм, орчны нөхцлөөс хамааран хэлбэрээ өөрчилдөг боловч голдуу бөөрөнхий, чийглэг, тунгалаг, нэвт гэрэлтсэн, цус задлахгүй байдаг. Каталлаза, оксидаза эерэг, цус ийлдэстэй нийлмэл орчнууд, триптоз буурцагт агар болон тиамин, никотин витамин, амин хүчил нэмсэн бусад синтетик орчнуудад сайн өсгөвөрлөгддөг. Харин шингэн тэжээлт орчинд нэгэн жигд булингар үүсгэх ба хальсан бүрхэвч үүсгэхгүй. Амьдрах орчны тохиромжтой нөхцөл нь 36–37°C, рН–7.2–7.4 байна. Өсөлт үржлийн хязгаар температур нь 20°C болон 40°C орчим байна.

Бруцеллагийн эсийн хана нь бусад грам сөрөг бактериудын адил эсийн хана нь дотор цитоплазмын мембраны гадуур хатуу пептидогликаны нимгэн үе түүний гадуур голчлон фосфолипид, липополисахарид, уургаас бүрдэхээс гадна мембранаар хучигдсан байдаг. Орчин үед бруцеллан эсрэгтөрөгчид нь эсийн ханын липополисахарид, 20 орчим төрлийн уураг, гликопротеиноос тогтдог. Тохиромжтой нөхцөлд бруцелла нь хурдан өсгөвөрлөгдөх боловч эмгэгт материалаас шууд суулгалт хийхэд 2 долоо хоног шаарддаг. Хатуу тэжээлт



орчинд бруцеллаг өсгөвөрлөхөд 3-5 хоногоос тэжээлт орчинг жигд булингартан шаравтар тунгалаг гөлгөр гадаргуутай клон үүсгэдэг. В. Д. Тимаков (1973) *B. melintensis*, *B. suis* хоёр хүчилтөрөгч хангалттай орчинд сайн өсгөвөрлөгддөг, *B. abortus*-н анхны ургалтын үед хүчилтөрөгчийн хамгамжийг бууруулж нүүрстөрөгчийн хангамжийг 10% хүртэл ихэсгэх хэрэгтэй гэж үзжээ. Бруцеллёз өвчний тархалт 2008 оны байдлаар дэлхийн 60 гаруй улс орнуудад бүртгэгдсэнээс манай оронд жилд дундажаар 400-500 хүн буюу 10000 хүн ам тутамд 1-2 хүн шинээр уг өвчнөөр өвчилж байна. Швейцарын хөгжлийн агентлагаас манай оронд хэрэгжүүлж буй “Малын эрүүл мэнд” төслийн хүрээнд 2010 онд Завхан, Сүхбаатар аймгуудад хийсэн судалгаагаар малын бруцеллёзын халдварлалтын түвшин харилцан адилгүй байв. Тухайлбал, Сүхбаатар аймагт хонинд 7.1%, ямаанд 5.1%, үхэрт 7.8%, тэмээнд 3.3%, адуунд 0.9%, нохойнд 41.3%, харин Завхан аймагт зөвхөн ямаанд 0.06%, үхэрт 5.0% - ийн халдварлалттай байжээ (Б.Золзаяа нар, 2011).

Монгол улсын Төрөөс 2011 онд гүйцэтгэсэн зорилтот тандалт шинжилгээнд Улаанбаатар болон 21 аймгийн 337 сум, 1107 баг, 11723 өрх айлын 168027 малаас (тэмээ 10937, үхэр 36318, хонь 59946, ямаа 60826) цус авч ийлдсийг Розбенгалын урвалаар шинжилгээ хийсэн байдаг. Үүнээс нийт малын 0,65%, тэмээний 0.68%, үхрийн 1.55% тус тус эерэг дүн үзүүлсэн байна.

МЭӨ тооллын 450-425 оны үед Грекчүүд адууны ям өвчний тухай анх удаа, үүнээс хойш эртний Римчүүд МЭ-ний тооллын 400-500 онд тодорхой мэдээллэж, халдвартай өвчин болохыг нь тодорхойлсон байна [4,5]. Адууны ям өвчин дэлхийн олон оронд тархан халдварлаж, улс орны эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, улмаар улсын аюулгүй байдалд ихээхэн аюул занал учруулсаар ирсэн бөгөөд сүүлийн 100 гаруй жилийн хугацаанд уг халдварын тархалтын цар хүрээ хумигдаж, шинэ тохиолдлын тоо ихээхэн цөөрсөн боловч [6,7,8] сүүлийн жилүүдэд энэхүү халдварт өвчний шинэ тохиолдол дэлхийн хэд хэдэн бүс нутагт шинээр болон дахин бүртгэгдсэн төдийгүй Европын зарим орон, АНУ-ын нутаг дэвсгэрт гаднаас орж ирсэн мал, амьтанд ч халдвар оношлогдсон байна. Ойрхи Дорнод, Арабын хойг, Өмнөд Америк, Хойд Африк, Зүүн болон Төв Азийн бүс, тухайлбал Бразил, Бахрейн, Сири, Иран, Ирак, Кувейт, Афганистан, Пакистан, Энэтхэг зэрэг улсад энэ өвчний хэд хэдэн удаагийн тохиолдол 2000-2015 онд бүртгэгдсэн.

Ям өвчний үүсгэгч *Burkholderia mallei* (*B. mallei*) нь грам сөрөг, хөдөлгөөнгүй, үрэнцэр, бүрээс үүсгэдэггүй, мөхлөг бүхий савханцар ба тэжээлт орчны төрөл, өсгөвөржилтийн хугацаанаас хамаарч савханцрын хэлбэр, хэмжээ янз бүр байдаг байна.

#### 4. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Адууны ям, малын бруцеллөз үүсгэгчийн фенотип болон генотип (зарим генийн нуклеотидийн дарааллын тогтоох) шинж чанар тодорхойлогдсон омог бий болгох зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллав.

1. Адууны ям, малын бруцеллөз үүсгэгчийг хайх, гарган авах.
2. Гарган авсан үүсгэгчээс шилэн сонгох, сонгогдсон өсгөврийн фенотип шинж чанарыг судлах.
3. Фенотип шинж чанар нь тодорхойлогдсон өсгөврийн зарим генийн нуклеотидийн дарааллыг тогтоох.
4. Нуклеотидийн дарааллыг нь тогтоосон дарааллыг олон улсын ген банк (NCBI)-д бүртгүүлэх

#### 5. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН АРГА ЗҮЙ

Судалгааны ажлыг Мал эмнэлгийн хүрээлэнгийн Халдварт өвчин, дархлаа судлалын лабораторид гүйцэтгэв. Судалгаанд ХӨДСЛ-ийн омгийн санд хадгалагдаж байгаа бруцеллан лавлагаа омгууд (*B. melitensis* 16М, *B. abortus* 544, бусад) болон шинээр гарган авсан *B. abortus*, *B. melitensis*, *B. mallei* төст өсгөврүүд бусад эм урвалжуудыг ашиглав.

##### 5.1. ҮҮСГЭГЧ ГАРГАН АВАХ, ТҮҮНИЙ ФЕНОТИП СУДАЛГАА

###### 5.1.1. Бруцеллөзын үүсгэгч гарган авах, шилэн сонгох

Нян судлалын шинжилгээнд Дундговь аймгийн Өлзийт сумын тэмээний 23, Архангай аймгийн зарим сумдын сарлагаас нийт 18, нийт 41 нян судлалын материал (үтрээний арчдас, сүү, цус)-ыг урьдчилан бэлтгэсэн бруцелла өсгөвөрлөх сонгомол тэжээлт орчин болох СІТА (Blood Agar, Base No2. (OXOID) 5%-ийн тугалын ийлдэс, антибиотик (vancomycin, colistin, nystatin, nitrafurantoin))-той орчинд суулгалт хийж, 37°C-н CO<sub>2</sub> той болон CO<sub>2</sub>гүй дулаан тогтоогуурт 72 цаг болон түүнээс цааш хугацаанд байлган өсгөвөрлөв. Бруцелла төст өсгөврүүд (нянгийн клонийн хэлбэр зүй, хэмжээ, өнгө зэргээр)-ийг сонгон авч, нян судлалын шинжилгээ хийн баталгаажуулав.

Мөн омог, өсгөврийн санд хадгалагдаж байгаа бруцеллөзын баталгаажуулсан үүсгэгч болон лавлагаа омог (лавлагаа омог: *B. melitensis* 16М, *B. abortus* 544, хониноос гарган авсан: *Sh-4*, *Sh-8*, *Sh-37*, *Sh-39*, ямаанаас гарган авсан: *Go-9*, *Go-10*, үхрээс гарган авсан: *B-2* зэрэг)-ууд болон судалгааны явцад **сарлагаас гарган авсан** *Y-8*, *Y-9*, *Y-11.*, **тэмээнээс гарган авсан** *Sam-1*, *Sam-2* зэрэг бруцелла төст өсгөврүүдийг шилэн сонгож, судалгаанд ашиглав.

###### 5.1.2. Адууны ямын үүсгэгч гарган авах, шилэн сонгох

Адууны ям өвний үүсгэгчийг 4% глицерин, 0.3% Meat extract, 5% адууны ийлдэс болон нэмэлтээр антибиотикүүд (Vancomycin, Streptomycin)–аар баяжуулж “Brain Heart infusion

broth” болон “Blood agar base”-ийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу бэлтгэн, ариун цэврийг шалган, судалгаанд ашиглав.

Хуурамч ямын үүсгэгч *Burkholderia pseudomallei*-с ялгаварлан танихын тулд 1%-н хагас шингэн орчинд хөдөлгөөнийг шалгах болон *Burkholderia pseudomallei*-ийн сонгомол тэжээлт орчин болох Mac-Conkey агарт өсгөвөржих байдал зэргээр шалгав.

### **5.1.3. Шилэн сонгосон өсгөврийн фенотип судалгаа**

**Хэлбэр зүй, будагдах байдал:** Бруцеллөзын нян судлалын шинжилгээний үр дүнд шинээр гарган авсан өсгөврүүд, омгийн сангаас сонгогдсон лавлагаа омог, өсгөвөр зэрэг нийт 14 ширхэг **бруцеллагийн өсгөвөр** болон адууны ямын үүсгэгч болох шинээр гарган авсан *Burkholderia* spp төрлийн **3 өсгөвөрүүдээс** түрхэц бэлтгэн, грамын аргаар будаж, нянгийн хэлбэр зүй, будагдах байдлыг тодорхойлсон.

**Будагтай тэжээлт орчны тест:** Бруцелла төрлийн өсгөврүүдийг будагтай тэжээлт орчин (Dye test)-д өсгөвөржих байдлаар нь ялган дүйв. Үүнд: Тионин 20 мкл/мл, Фуксин 20 мкг/мл-р агуулсан тэжээлт орчин бэлтгэн, хяналтаар *B. melintensis* 16М, *B. abortus* 544 зэрэг лавлагаа омог ашиглан шалгав.

**Фагад идэгдэх байдал:** Бруцелла төрлийн өсгөврүүдийг фагад идэгдэх байдлын шалгалт (Phage typing)-аар зүйл, ийлдсэн хэвшлийг нарийвчлан тодорхойлов. Судалгаанд ТВ, WB, IZ ба R/C фагуудыг ашиглав.

**Анти А болон М эерэг ийлдсээр бруцелла төрлийн өсгөврийн төрөл, зүйлийг тодорхойлох:** Урьдчилж бэлтгэсэн өсгөврийн цийдмэгээс шилэн хавтан дээр 0.1 мл дусаан адил хэмжээний Анти А болон М ийлдэснээс дусаан, 2 минутийн турш холин, ээдэлтээр үр дүнг дүгнэв.

## **5.2. ГЕНОТИП СУДАЛГАА**

### **5.2.1. Нянгийн геномын дезоксирибонуклейн хүчил (ДНХ) ялгах**

**Уламжлалт аргаар ялгах:** Судалгаанд ашигласан бруцеллөз (14 өсгөвөр) болон адууны ямын үүсгэгч (3 өсгөвөр) – ийг тухайн тохирох хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөн, өсгөвөржилт гүйцсэний дараа 5 хүртэл тусгаар клонийг нянгийн гогцоогоор хусан авч, үүнийг 200 мкл ариун нэрмэл устай цодонд хийн, сайтар хольж хутгав. Урьдчилж халаасан, +100 хэмээс дээш усанд 5 минутийн турш буцалгав. Буцалгасны дараа 12000 эргэлт/минут хурдаар 10 минутийн турш хурилдуурдав. Дээр нь үүссэн шингэн (супернатант)-г асган, үлдсэн тунадас (нянгийн геномийн ДНХ)-г 100 мкл ариун нэрмэл усанд уусган авч, цаашдын молекул биологийн шинжилгээнд ашиглав.

**Фенолхлорформын аргаар ялгах:** Судалгаанд ашигласан бруцеллөз (14 өсгөвөр) болон адууны ямын үүсгэгч (3 өсгөвөр) - ийг тухайн тохирох шингэн тэжээлт орчинд өсгөвөрлөн, өсгөвөржилт гүйцсэний дараа шингэнээс 1000-2000 мкл авч, 12000 эрг/миу хурдаар 10 минут хурилдуулан, дээд шингэнийг асгаж 50 мкл ариун нэрмэл усанд хийн цийдмэгжүүлэв. Үүний дээр 450 мкл хайлуулагч уусмал (Lysis buffer) нэмэв. Уг хайлуулагч уусмал нэмсэн хэсэг дээр 5 мкл протейназа К-гийн уусмал нэмэн 55°C-д 2 цаг инкубацлан 30 мин тутамд сэгсэрч байв. Фенол-хлорформ-изоамилийн спиртийн холимогоос 500 мкл хийн 2 мин холигч (Vortex)-оор холив. Хольсон шингэнээ тасалгааны температурт 15000 эрг/минутаар 5 мин хурилдуулав. Хугацааны дараа ДНХ бүхий дээд үеийн шингэнээс 500 мкл-ийг соруулан авч дээр нь 3М NaCl-ын уусмал 40 мкл болон 1 мкл 100% этилийн спирт тус тус нэмэн -20°C-д 30 мин байлган тунадасжуулав. Үүнийг дахин 4°C-д 30 мин тунадасжуулсаны дараа 4°C-д 15000 эрг/мин-д 20 мин хурилдуурдав. Дээд шингэнийг тунадасыг хөдгөлгүйгээр соруулан авав. Тунадас дээр 100 мкл 70% этанол нэмэн тасалгаанд хэсэг хугацаанд байлгасны дараа 4°C-д 15000 эрг/мин хурдаар 5 мин хурилдуулсан. Дээд шингэнийг соруулан авч үлдсэн шингэн хэсгийг агаарт хатаав. Хатаасан дээр 20 мкл ТЕ буфер нэмэн ДНХ-г уусган авав.

### **5.2.2. Полимеразын гинжин урвал (ПГУ)-аар баталгаажуулах**

#### **Бруцеллагийн төрөл, зүйл баталгаажуулах ПГУ**

Шинээр гарган авсан болон хяналтаар ашигласан омог, өсгөврүүдийн төрөл, зүйлийг тодорхойлох зорилгоор дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-ын зөвлөдөг 8 хос өвөрмөц праймер бүхий BRUCE – LADDER мультитплекс ПГУ-ыг хийж гүйцэтгэв (1-р хүснэгт).

1-р хүснэгт. BRUCE-LADDER ПГУ-д хэрэглэдэг праймерийн мэдээлэл

Бай ген	Праймерийн нэр	Нуклеотидийн Дараалал (5' – 3')	ПГУ-ын бүтээгдэхүүн (bps)
Glycosyltransferase, gene wboA	BMEI0998f BMEI0997r	ATC CTA TTG CCC CGA TAA GG GCT TCG CAT TTT CAC TGT AGC	1682
Immunodominant antigen, gene bp26	BMEI0535f BMEI0536r	GCG CAT TCT TCG GTT ATG AA CGC AGG CGA AAA CAG CTA TAA	450
Outer membrane protein, gene omp31	BMEII0843f BMEII0844r	TTT ACA CAG GCA ATC CAG CA GCG TCC AGT TGT TGT TGA TG	1071
Polysaccharide deacetylase	BMEI1436f BMEI1435r	ACG CAG ACG ACC TTC GGT AT TTT ATC CAT CGC CCT GTC AC	794
Erythritol catabolism, gene eryC (d-erythrulose-1-phosphate dehydrogenase)	BMEII0428f  BMEII0428r	GCC GCT ATT ATG TGG ACT GG  AAT GAC TTC ACG GTC GTT CG	587
ABC transporter binding protein	BR0953f BR0953r	GGA ACA CTA CGC CAC CTT GT GAT GGA GCA AAC GCT GAA G	272
Ribosomal protein S12, gene rpsL	BMEI0752f BMEI0752r	CAG GCA AAC CCT CAG AAG C GAT GTG GTA ACG CAC ACC AA	218
Transcriptional regulator, CRP family	BMEII0987f BMEII0987r	CGC AGA CAG TGA CCA TCA AA GTA TTC AGC CCC CGT TAC CT	152

### **Адууны ямын үүсгэгчийг баталгаажуулах ПГУ**

Адуунаас ялган авсан *Burkholderia* төст өсгөврийг ДМАЭМБ-ын зөвлөдөг *B. mallei* – ийн 23S rDNA болон шилбүүрийн генд суурилсан праймер ашиглан ПГУ -аар баталгаажуулав (2-р хүснэгт).

2-р хүснэгт. Адууны ямын үүсгэгчийг ялган таних ПГУ- хэрэглэдэг праймерийн мэдээлэл

Бай ген	Праймерийн нэр	Нуклеотидийн Дараалал (5' – 3')	ПГУ – ын бүтээгдэхүүн (bp)
Шилбүүрийн ген (Filagella)	Bma-IS407-flip-f	TCA GGT TTG TAT GTC GCT CGG	1,682
	Bma-IS407-flip-r	CTA GGT GAA GCT CTG CGC GAG	
23S rDNA	VMP23-1	CTT TTG GGT CAT CCT RGA	1051
	M23-2	CAC CGA AAC TAG CA	
	MP23-2	TCC TAC CAT GCG AGA CT	
	CVMP23-1	AAA CCG ACA CAG GTG G	526
	CVP23-2	CAC CGA AAC TAG CG	

#### **5.2.3. Нуклеотидийн дарааллыг боловсруулах, генбанканд бүртгүүлэх**

ПГУ-ын бүтээгдэхүүнийг “Universal DNA purification kit” цомог ашиглан зааврын дагуу цэвэршүүлж “Занаа спекс” ХХК-аар дамжуулан Хятад улсад нуклеотидийн дарааллыг тогтоолгов. Нуклеотидийн дарааллыг Snapgene 2.3.2 болон Muscle програмуудыг ашиглан шууд болон урвуу праймераар уншуулсан дээжүүдийг нэгтгэн бүтэн дараалал болгон бэлэн болсон дарааллуудыг NCBI генбанканд бүртгүүлж филогенетикийн анализ хийв.

#### **5.2.4. Удам зүйн мод байгуулах**


“MEGA 7.0” (Koichiro Tamura 2012) программ ашиглан, түгээмэл ашигладаг хамгийн бага өөрчлөлтийг илүү нарийн гаргахын тулд хамгийн их магадлал (ML) болон зайг үнэлэх (NJ) аргуудаар “Кимура 2 параметр” загварт суурилан “Bootrtrap 1000 репликаци” байхаар тоохон филогенетикийн мод байгуулсан. Эдгээр аргуудыг ашигласнаар дарааллуудыг олон талаас харах боломжтойгоос гадна филогенетик мод хоорондоо нийцэж байгаа эсэхийг харах боломжтой юм.

Maximum Parsimony арга нь тодорхой дараалалуудад ажиглагдсан вариансийг тооцох олон шатуудыг багасгадаг тул заримдаа хамгийн бага хувьслын арга гэж нэрлэдэг. Удмын мод байгуулахдаа тухайн дараалал дахь хамгийн бага хувьслын зэргийг тооцож, үлдсэн бүх дараалалуудтай жиших замаар боломжит хамгийн бага хувьслыг агуулсан удмын мод байгуулдаг. Энэ үүднээсээ хоорондоо маш төсөөтэй цөөн тооны дарааллуудын удмын мод байгуулахад тохиромжтой байдаг.


## 6. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### 6.1. Бруцеллёз үүсгэгчийн нян судлалын шинжилгээний дүн

Сарлагаас цуглуулсан сүү, үтрээний арчдасаас СИТА хатуу тэжээлт орчинд тарилт хийхэд 3 бруцелла төст өсгөвөр өсгөвөрлөгдөв. Эдгээр өсгөврүүдийн клон нь жижиг, тунгалаг, цайвар шаргалдуу байсан ба CO<sub>2</sub> шаардаж 72 цаг ба түүнээс дээш хугацаанд өсгөвөрлөгдсөн (Зураг 1А). Түрхэц бэлтгэн грамын аргаар будаж шалгахад маш жижиг, грам сөрөг савханцарууд тодорхойлогдсон (Зураг 1Б). Шилэн сонгосон өсгөврүүдийг бруцеллагийн лавлагаа омог (*B. abortus* 544, *B. melitensis* 16М)-уудтай харьцуулан будагтай тэжээлт орчинд өсгөвөрлөх, зүйл өвөрмөц фагад идүүлэх, зүйл өвөрмөц эсрэг А болон М эерэг ийлдэстэй наалдалтанд орох болон будагтай тэжээлт орчингуудад өсгөвөрлөгдөх байдал зэргээр дүйж өсгөврийн төрөл зүйлийг ялган тодорхойлоход дараах үр дүн гарав (Зураг 2А болон Б) (3-р хүснэгт).



Зураг 1. А-Гарган авсан бруцеллын өсгөвөр хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөгдсөн байдал. Б-Гарган авсан өсгөвөр нь грамын аргаар будагдсан байда. /10x100/ өсгөлт



Зураг 2. Гарган авсан бруцелла төст өсгөвөр.

А. Фуксинтэй тэжээлт орчинд өсгөвөрлөгдсөн байдал.

Б. Тионинтэй тэжээлт орчинд өсгөвөржсөн байдал

3-р хүснэгт. Өсгөвөр, омгуудын фенотип шинж чанарын үзүүлэлт


Омог, өсгөврийн нэр	Эзэн амьтан	CO <sub>2</sub> шаардах эсэх	Будагтай т/орчинд өсгөвөрлөгдөх бейдал		Эерэг ийлдэс		Фаг-д идэгдэх байдал			
			Тионин	Суурьлаг фуксин	А	М	Тb	Wb	Iz	R/C
<i>B. abortus</i> 544	Лавлагаа	+	+	-	+	-	-	+	-	-
<i>B. melitensis</i> 16M	омог	-	+	+	-	-	-	-	-	-
1130603		+	+	+	+	-	-	-	+	-
12203008	Сарлаг	+	+	+	+	-	-	-	+	-
1110403		+	+	+	+	-	-	-	+	-
Sh 4		-	+	+	-	-	-	-	-	-
Sh 8	Хонь	-	+	+	-	-	-	-	-	-
Sh 37		-	+	+	-	-	-	-	-	-
Sh 39		-	+	+	-	-	-	-	-	-
Go 9	Ямаа	-	+	+	-	-	-	-	-	-
Go 10		-	+	+	-	-	-	-	-	-
Y 8		+	+	+	+	-	-	-	+	-
Y 9	Сарлаг	+	+	+	+	-	-	-	+	-
Y 11		+	+	+	+	-	-	-	+	-
Cam 1	Тэмээ	+	+	+	+	-	-	-	+	-
Cam 2		+	+	+	+	-	-	-	+	-
B 2	Монгол үхэр	+	+	+	+	-	-	-	+	-

**6.2. Адууны ям үүсгэгчийн нян судлалын шинжилгээний үр дүн**

Ийлдэс судлалын шинжилгээгээр эерэг урвал өгсөн адууг зориуд нядлан, сорьц авч, нян судлалын шинжилгээг хийхэд *Burkholderia mallei* төст 3 өсгөвөр гарган авсан. Төст өсгөвөр нь хатуу тэжээлт орчинд 24 цаг өсгөвөрлөхөд жижиг цайвар “S” хэлбэрийн клон үүсгэж өсгөвөржих ба 48-72 цагуудад клонийн хэлбэр өөрчлөгдөж томрон, зах нь жигд биш хэмтэй, цайвар цагаан өнгөтэй клон болж байв (Зураг 3 А).

Глицеринээр баяжуулсан тархи зүрхний шөлөнд булингар үүсгэхгүй, сэгсрэхэд тунадас суусан байгаа нь ажиглагдаж өсгөвөрлөгдөв. (Зураг 3Б) 24-72 цагийн өсгөвөр нь грам сөрөг, жижиг савханцар байв (Зураг 3В).






Зураг 3. А- Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөгдсөн *B. mallei* төст өсгөврийн клонийн хэлбэр зүй,

Б – шингэн тэжээлд өсгөвөржсөн *B. mallei* төст өсгөвөр,

В – *B. mallei* төст өсгөврийг грамын аргаар будсан байдал

Хуурамч ям өвчин үүсгэгч *B. pseudomallei* – аас ялгаварлан таних сонгомол арга болох нянгийн эсийн хөдөлгөөнийг хагас шингэн орчинд өсгөвөрлөхөд зөвхөн хатгалтын дагуу өсгөвөржиж уг өсгөвөр нь хөдөлгөөнгүй болох нь батлагдсан (Зураг 4А). Мөн дээрх өсгөвөр нь МакКонкейн сонгомол орчинд өсгөвөрлөгдөөгүй болно (Зураг 4Б). Цустай агарт тарилт хийж 24-72 цагийн турш өсгөвөрлөхөд цус задлалтын бүс үүсгээгүй байв (Зураг 4В).



Зураг 4. А-Хагас шингэн агарт өсгөвөржсөн *B. mallei* төст өсгөвөр,

Б-Макконкейн агарт өсгөвөржсөн *B. mallei* төст өсгөвөр,


В-Цустай агарт өсгөвөржсөн *B. mallei* төст өсгөвөр

### 6.3. Молекул биологийн шинжилгээний дүн

#### 6.3.1. Бруцеллөз үүсгэгчийг ПГУ – аар баталгаажуулсан дүн


Судалгаанд ашигласан омог, өсгөврүүд болох омгийн санд хадгалагдаж байгаа бруцеллөзын баталгаажуулсан үүсгэгч болон лавлагаа омог (лавлагаа омог: *B. melitensis* 16М, *B. abortus* 544, хониноос гарган авсан: Sh 4, Sh 8, Sh 37, Sh 39, ямаанаас гарган

авсан: Go-9, Go-10, үхрээс гарган авсан: B-2 зэрэг)-ууд болон судалгааны явцад **сарлагаас гарган авсан** Y-8, Y-9, Y-11., **тэмээнээс гарган авсан** Cam-1, Cam-2 зэрэг бруцелла төст өсгөврүүдийн төрөл зүйлийг баталгаажуулах зорилгоор бруцеллагийн OMP28, OMP31 болон Vcsp31 генүүдийг илрүүлэх ПГУ явуулахад бүгд эерэг үр дүн үзүүлэв (Зураг 5, 7). Мөн Тэмээнээс ялгасан 2, сарлагаас ялгасан төст өсгөврүүд нь бүгд Bruce - Ladder ПГУ - аар **Brucella abortus** болох нь тус тус батлагдав (Зураг 6).




Зураг 5. Бруцеллагийн Vcsp31 генийг илрүүлэх ПГУ-ын үр дүн

M- 500 bps маркер, 1-B. abortus 544, 2-B. melitensis 16M, 2-15 илрүүлсэн өсгөврүүд (1130603, 12203008, 1110403, Sh-4, Sh-8, Sh-37, Sh-39, Go-9, Go-10, Y-8, Y-9, Y-11, Cam-1, Cam-2, B-2 зэрэг дугаартай өсгөврүүд)



Зураг 6. Бруцеллагийн төрөл, зүйлийг баталгаажуулах bruce-ladder ПГУ-ын үр дүн.

1- 500 bps маркер, 2-200 bps маркер 3-B. abortus 544, 4-B. melitensis 16M 5-1130603 дугаартай өсгөвөр (тэмээ), 6-12203008 дугаартай өсгөвөр (тэмээ), 7-1110403 дугаартай өсгөвөр (сарлаг)




Зураг 7. Бруцелла төст өсгөвөрүүдэд OMP28 уургийн генийг илрүүлэх ПГУ-ын үр дүн  
M- 500 bps маркер, 1-*B. abortus* 544, 2-*B. melitensis* 16M, 2-15 илрүүлсэн өсгөвөрүүд  
(1130603, 12203008, 1110403, Sh-4, Sh-8, Sh-37, Sh-39, Go-9, Go-10, Y-8, Y-9, Y-11, Cam-1,  
Cam-2, B-2 зэрэг дугаартай өсгөвөрүүд)


### 6.3.2. Адууны ямын үүсгэгчийн ПГУ-аар баталгаажуулсан дүн:

Судалгааны үр дүнд гарган авсан *B. mallei* төст өсгөврүүдөөс ялгасан гДНХ-г ашиглан 50 мкл эзэлхүүнд ПГУ-ыг гүйцэтгэв. ПГУ-ын бүтээгдэхүүнийг 1.5%-иар бэлтгэсэн агароз гельд 5 мкл-ээр ачааллаж 100V-ийн хүчдэлээр 30 мин гүйлгэж UV гэрлээр харж үр дүнг тодорхойлов.

Зөвхөн *Burkholderia*-н 23S rDNA-н өвөрмөц хэсэгт суурилсан праймер (M23-2, CVMP23-1, өрсөлдөгч праймер CVP23-2) бүхий ПГУ-аар дээрх өсгөврүүд бүгд *Burkholderia*-ийн төрөлд өвөрмөц буюу 526 bps-ийн хэмжээ бүхий толбо өгөв (Зураг 8). Мөн Bma-IS407-flip-f, Bma-IS407-flip-r праймеруудаар ПГУ-ыг гүйцэтгэхэд 986 bps-ийн уртад өвөрмөц толбо илэрч *Burkholderia mallei* зүйл болох нь тус тус батлагдаж байна. (Зураг 9)




Зураг 8. *Burkholderia*-ийн төрлийн нянг илрүүлэх өрсөлдөөнт ПГУ-ын үр дүн  
M- 200 bps маркер, 1-*Burkholderia mallei*-ийн эерэг хяналт, 2-сөрөг хяналт, 3-*Burkholderia*  
төст өсгөвөр BmMGL20190501, 4- *Burkholderia* төст өсгөвөр BmMGL20200102



Зураг 9. *Burkholderia mallei*-ийн төрлийн нягн илрүүлэх өрсөлдөөнт ПГУ-ын үр дүн  
M- 200 bps маркер, 1 болон 2-*Burkholderia mallei*-ийн эерэг хяналт, 3-*Burkholderia mallei* төст  
өсгөөр BmMGL20190501, 4- *Burkholderia mallei* төст өсгөөр BmMGL20200102, 5-сөрөг  
хяналт,

#### 6.4. Нуклеотидийн дарааллыг тодорхойлж, генбанканд бүртгүүлсэн дүн

Бруцеллагийн “Omp28”, “Omp31” болон “Vcsr31” генүүдийн, *B. mallei*-ийн “Flip” ген болон “23S rPHX”-ийн нуклеотидийн дарааллыг тодорхойлов. Snapgene 2.3.2 программ ашиглан үр дүнг боловсруулахад ихэнх нь амжилттай уншигдсан ба чанарын хувь нь 80-90%-тай байгаа нь шаардлага хангаж байв. Шууд болон урвуу праймераар уншуулсан дарааллуудыг SnapGene программыг ашиглан тэнцүүлж, бүтэн дараалал болгож филогенетикийн судалгаа хийхэд хангалттай гэж үзэн дараагийн боловсруулалтад оруулав.



Зураг 10. *Brucella spp* төрлийн болон *Burkholderia mallei*-ийн бай генүүдийн нуклейтидын дараалалыг тогтоосон дүн. Жишээ болгон зарим генийн нуклеин хүчлийн дарааллын хэсгийг үзүүлэв. Үүнд: А) *B. abortus* бактерийн Omp28 генийн хэсэг; Б) *B. melitensis* бактерийн Omp31 генийн хэсэг; В) *B. abortus* бактерийн Vcsp31 генийн хэсэг; Г) *B. mallei* бактерийн Flp генийн хэсэг; Д) *B. mallei* бактерийн 23S rPHX-ийн хэсэг

Мөн тодорхойлсон нуклеотидийн дараалалуудыг MUSCLE программ ашиглан жишиг дараалалтай харьцуулалт хийхэд бусад судлаачдын үр дүнгээр гарсан дарааллуудтай 99% таарч байв (Зураг 11).

“Адууны ям, малын бруцеллэз үүсгэгчийн фенотип, генотипийн судалгаа” 2018-2021 он

<b>А</b>	эх-дараалал Bcsp31-5	C6CCTTGCCTTTCAGGCTGCGACCGATTGATGTTTGATCCTTACGCGCAAGCAT CGCGCTG6CCTTTCAGGCTGCGACCGATTGATGTTTGATCCTTACGCGCAAGCAT *****	<b>Б</b>	эх Flip2	-----GTGCTGCTGCTGCGAGCGGATCGGCACCGGCTC AAGCTTACGGGGAATACTGCTGGGCTGCGAGCGGATCGGCACCGGCTC *****
	эх-дараалал Bcsp31-5	GGATCGTTCCGGGTAAAGCGTGCAGAAAGCGCAAATCTTCCACTTGCCTTGCAT GGATCGTTCCGGGTAAAGCGTGCAGAAAGCGCAAATCTTCCACTTGCCTTGCAT *****		эх Flip2	GACGCCCGGAATCAGTGTGCTGCGGCTCGCCCTTCTCTCAGCGTGTGATGTC AACACCGCGAAGCAGGGGCTCGCGGCTCGCCCTTCTCTCACAATGTTGATGTC *****
	эх-дараалал Bcsp31-5	CATAAAGCCGGTCCGTTATAGCCCAATAGCAACGTCTGACTGCGTAAAGCGGACT CATAAAGCCGGTCCGTTATAGCCCAATAGCAACGTCTGACTGCGTAAAGCGGACT *****		эх Flip2	GCCCGTCTGACCCGCGTACACAGCGCTACAAGCGTTTCCGAGGCGACGCTGCA CCCGTCTGACCCGCGAGTACAAGCGCAGCAAGCGCTTTCAGGCGCACGTCGA *****
	эх-дараалал Bcsp31-5	CCAGAGCGCCGACTTGCATGATATGCAACCGAGCA -----		эх Flip2	GATGGACAGCGGTCAGCGCGGACCGGCCCTTCAAGCGTTATGCTCAAGCAGAC GATGGACAGCGGTCAGCGCGGACCGGCCCTTCAAGCGTTATGCTCAAGCAGAC *****
<b>Б</b>	эх-дараалал Omp28-2	AAAGTCTCGATGCCATGAAGAAGCGCCGATCGAAGATCGCGATCTCAGACAGCGCGC AAAGTCTCGATGCCATGAAGAAGCGCCGATCGAAGATCGCGATCTCAGACAGCGCGC *****	эх Flip2	GATGGACAGCGGTCAGCGCGGACCGGCCCTTCAAGCGTTATGCTCAAGCAGAC GATGGACAGCGGTCAGCGCGGACCGGCCCTTCAAGCGTTATGCTCAAGCAGAC *****	
	эх-дараалал Omp28-2	ATCAATATCCAGCGGATTATGCTATCTGACGACAGCAACCTGAAAGCGCTACC ATCAATATCCAGCGGATTATGCTATCTGACGACAGCAACCTGAAAGCGCTACC *****	эх Flip2	GCGGAGACCGATCTGCGCTGTTCCGGAAGATCTCAAGCGCGCGGATGCAAGCGCC GCGGAGACCGATCTGCGCTGTTCCGGAAGATCTCAAGCGCGCGGATGCAAGCGCC *****	
	эх-дараалал Omp28-2	ATCACGGCTATCTGTATCCACCGTCTCACGTTCCGCGTGCAGCACTGCGCAATGT ATCACGGCTATCTGTATCCACCGTCTCACGTTCCGCGTGCAGCACTGCGCAATGT *****	эх Flip2	GGAGGACGTCGCGCTGCTGCTGCTGCGCGGCTTCTGCAACAAGCGCTGAAAGCGG GGAGGACGTCGCGCTGCTGCTGCTGCGCGGCTTCTGCAACAAGCGCTGAAAGCGG *****	
	эх-дараалал Omp28-2	GGAAAAATTTGGATGAATCCGTCAGCGTGGTGTAAATCAGGCGGTTGATGAACTG GGAAAAATTTGGATGAATCCGTCAGCGTGGTGTAAATCAGGCGGTTGATGAACTG *****	эх Flip2	GTTCAGATCGGCTTCAAGCTTCTATCCGTTTCTCATCATGACATGGTTGTGCGAG GTTCAGATCGGCTTCAAGCTTCTATCCGTTTCTCATCATCAACATGCTGTGCGAG *****	
	эх-дараалал Omp28-2	GTCAATGATAATCCCTCCGCGTGTCAAGCGCGCGCAAGCGCGAGTGGCAATGCC GTCAATGATAATCCCTCCGCGTGTCAAGCGCGCGCAAGCGCGAGTGGCAATGCC *****	эх Flip2	CGTCTGATGTCGATGGGATGATGATGGTGTGCGCCGC-GACGGTG--TCGCTGCGT CGTCTGATGTCGATGGGATGATGATGGTGTGCGCCGC-GACGGTG--TCGCTGCGT *****	
	эх-дараалал Omp28-2	ATTGCCAAGCGAAGACGCTTGCAGCGTGCAGGCGTGGGCTTGGCGTGTGGTGGAA ATTGCCAAGCGAAGACGCTTGCAGCGTGCAGGCGTGGGCTTGGCGTGTGGTGGAA *****	эх Flip2	CAAGCTGATGCTGTGCTGCTGCGACGGCTGGCAAGTGTGATGCGCTGCTGCGCA CAAGCTGATGCTGTGCTGCTGCGACGGCTGGCAAGTGTGATGCGCTGCTGCGCA *****	
	эх-дараалал Omp28-2	ATCAGTGAAGTGAAGCGCCCGCCATGCGGATGCGCAATGCGCGCGGACGTTCAAGCC ATCAGTGAAGTGAAGCGCCCGCCATGCGGATGCGCAATGCGCGCGGACGTTCAAGCC *****	эх Flip2		
	эх-дараалал Omp28-2	ATGCTAGCAGCGCACCAGCAATTCGTCGCGGATTGCCGAGCGGAAACAGCTATAAC ATGCTAGCAGCGCACCAGCAATTCGTCGCGGATTGCCGAGCGGAAACAGCTATAAC *****			

**Зураг 11. Нуклейн хүчлийн дарааллийг эх дараалалтай харьцуулсан дүн. Жишээ болгон зарим генийн харьцуулалтыг үзүүлэв. Үүнд: А) *B. abortus* бактерийн *Bcsp31* генийн хэсгийг эх дараалалтай харьцуулсан харьцуулалт; Б) *B. abortus* бактерийн *Omp28* генийн хэсгийг эх дараалалтай харьцуулсан харьцуулалт; В) *B. mallei* бактерийн *Flip2* генийн хэсгийг эх дараалалтай харьцуулсан харьцуулалт**

Үүний дараа бай нуклеотидийн дарааллыг тогтоосон бай гэнүүдийн дарааллыг олон улсын ген банканд бүртгүүлж, бүртгэлийн дугаарыг авав (4-р хүснэгт).

**4-р хүснэгт. Бруцелла төрлийн бактериудын *Omp28* генийн дарааллыг NCBI-д бүртгүүлэн бүртгэлийн дугаар (accession number)-ыг авав**

Зүйлийн нэр	Гаргаж авсан эзэн амьтан	Омгийн нэр	Генбанк дахь бүртгэлийн дугаар
<i>Brucella melitensis</i>	Ямаа	Go10	MN080913
<i>Brucella melitensis</i>	Хонь	Sh4	MN080914
<i>Brucella melitensis</i>	Хонь	Sh8	MN080915
<i>Brucella melitensis</i>	Хонь	Sh35	MN080916
<i>Brucella</i>	Хонь	Sh39	MN080917

<i>melitensis</i>			
<i>Brucella melitensis</i>	Ямаа	Go9	MN080918
<i>Brucella abortus</i>	Тэмээ	Cam1	MN080919
<i>Brucella abortus</i>	Тэмээ	Cam2	MN080920
<i>Brucella abortus</i>	Сарлаг	Y8	MN080921
<i>Brucella abortus</i>	Сарлаг	Y9	MN080922
<i>Brucella abortus</i>	Сарлаг	Y11	MN0809123
<i>Brucella abortus</i>	Үхэр	B2	MN080924

“***Burkholderia mallei*-ийн MNGBm20180501 омог**” нэртэй нутгийн адуунаас гарган авч, баталгаажуулсан омгийн “23s rRNA”-ын нуклеотидийн дараалал (506 хос нуклеотид)-ыг тодорхойлж, олон улсад өргөн ашиглагддаг, “NCBI” сайтын генбанкнаас “BLAST” хайлтын систем ашиглан хайлт хийхэд энэхүү омогт тодорхойлсон дараалал нь *Burkholderia mallei* ATCC 23344 жишиг омог (NCBI дахь бүртгэлийн дугаар NC006348.1., Alternative ID China 7, BMF., Source: Burma, Human, 1944, геномын нийт нуклеотидийн хэмжээ 3 510 148)-ийн геномын бүрэн дараалалтай харьцуулахад 97.39%-ийн (2672823 – 2675704 хүртлэх азотлог суурийн байрлал) таарамжтай, 2.61%-ийн зөрүүтэй үр дүн гарсан (Зураг 12).

[Burkholderia mallei strain 23344 chromosome 2, complete sequence](#)

846 846 97% 0.0 97.39%

Зураг 12. Олон улсын ген банкин дах *Burkholderia mallei* (CP010349.1) омгийн геномын бүрэн дараалалтай харьцуулж *Burkholderia mallei* MNGBm20180501 омгийн 23s rRNA генийн дарааллыг “NCBI-BLAST” хийсэн дүн

MNGBm20180501 дугаартай өсгөврийн 23s rDNA –ын нуклеотидийн дарааллыг тодорхойлж, NCBI сайтын Генбанканд хадлагдаж буй NR0763471.1 бүртгэлийн дугаартай *Burkholderia mallei* ATCC 23344–ын 23s rDNA генийн дараалал болон Y17184.1 бүртгэлийн дугаартай *Burkholderia pseudomallei*-ын 23s rDNA генийн жишиг дараалалтай MEGA7.0 программын CLUSTAL W программыг ашиглан харьцуулсан. Ингэхдээ GOP 15, GEP 6.66, IUB матриц буюу программын анхдагч өгөгдлийг ашиглан дарааллын мэдээллийг хооронд нь харцуулсан (Зураг 13)


✓1. Y17184.1 <i>Burkholderia pseudomallei</i> 23S rRNA gene	A A C C G A T C T G T A G G A T A G G T G G G A G G C T A T G A A A C C G G A A C G C T A G T T T C G G T G G A G C C G T C C T T G
✓2. NR_076347.1 <i>Burkholderia mallei</i> ribosomal RNA gene	A A C C G A T C T G T A G G A T A G G T G G G A G G C T A T G A A A C C G G A A T G C T A G T T T C G G T G G A G C C G T C C T T G
✓3. MNGBm20180501	A A C C G A T C T G T A G G A T A G G T G G G A G G C T A T G A A A C C G G A A T G C T A G T T T C G G T G G A . . . . .

Зураг 13. Олон улсын ген банкинд бүртгэлтэй *Burkholderia mallei* ATCC 23344–ын (Бүртгэлийн дугаар: NR0763471.1) болон *Burkholderia pseudomallei*-ын 23s rRNA (Бүртгэлийн дугаар: Y17184.1) зэргийн бүрэн дарааллыг MNGBm20180501-ийн 23s rRNA-ийн нуклеотидийн дараалалтай харьцуулсан дүн

Хуурамч ям өвчний үүсгэгч *B. pseudomallei* болон ямын үүсгэгч *B. mallei* -ын 23s rDNA генийн хувьд 2143 дахь тимин нь цитозин болж солигдсон гэж мэдээллэсэн байна. (Molecular Procedure for Rapid Detection of *Burkholderia mallei* and *Burkholderia pseudomallei*). Судалгаагаар тодорхойлсон дараалал нь NR0763471.1 бүртгэлийн дугаартай *Burkholderia mallei* ATCC 23344–ын 23s rDNA генийн дараалалтай адилхан байна. Мөн MonBm20180501 омгийн flir генийн 764 хос нуклеотид урттай дарааллыг NCBI генбанканд бүртгүүлэв (MZ380392).

Харьцуулалтын үр дүнд *B. pseudomallei* болон *B. mallei* зүйлүүдийн 23s rRNA-ийн генийн нуклеотидийн дарааллын 2143 дахь азотлог суурийн байрлал нь *B. mallei*-д Тимин (Т) байгаа бол *B. pseudomallei*-д Цитозин (Ц) болж солигдсон гэж мэдээллэсэн байна (Эх сурвалж: Adolf Bauernfeind et al. 1998., “Molecular Procedure for Rapid Detection of *Burkholderia mallei* and *Burkholderia pseudomallei*”). Бидний ирлүүлж, баталгаажуулсан “*Burkholderia mallei* MNGBm20180501 омог”-ийн 23s rRNA-ийн генийн нуклеотидийн дарааллын 2143 дахь байрлал нь *B. mallei* NR0763471.12-ийнхтэй адил буюу 2143 дахь азотлог суурийн байрлал Тимин (Т) байгаа нь энэхүү омог нь *B. mallei* зүйл болох нь батлагдаж байна (Зураг 14).

Нуклеотидийн дарааллыг тодорхойлсон нутгийн омгийн дарааллыг Snapgene 2.3.2 программ ашиглан боловсруулалт хийж нуклеотидийн дарааллын цэвэр уншигдсан байдлыг шалгав (Зураг 14)




Зураг 14. MNGBm20180501 дугаартай өсгөврийн 23s rRNA генийн хэсгийн 2143 дахь нуклеотид нь тимин болох нь тогтоогдсон

### 6.5. Удам зүйн мод байгуулсан дүн

Судалгаанд ашигласан омог, өсгөврүүдийн Vcsp31 болон OMP28 генийн дараалалд филогенетик анализ хийж, үр дүнд гаргахад хоёр мод нь тус тусдаа ерөнхий 1 кластерыг




үүсгэсэн. Энэ нь бидний тодорхойлсон нуклеотиднан дараалал нь жишиг дараалалуудтай хамаарал бүхий дараалал болох нь батлагдаж байгаа юм (Зураг 15А, Б).



Зураг 15. Нуклейн хүчлийн дарааллийг ашиглан филогенетикийн байгуулсан дүн. Үүнд:  
А) *B. abortus* бактерийн *Bcsp31* генийн филогенетикийн мод; Б) *B. abortus* бактерийн  
*Opr28* генийн филогенетикийн мод

MNGBm20180501 дугаартай нуклеотидийн дарааллыг Генбанканд хадлагдаж буй NR0763471.1 бүртгэлийн дугаартай *Burkholderia mallei* ATCC 23344 омгийн 23s RNA генийн жишиг дараалал мөн *B. mallei*-н ATCC15310 омгийн 23s RNA генийн дараалал болон Y17184.1 бүртгэлийн дугаартай *Burkholderia pseudomallei*-ын 23s RNA генийн жишиг

